

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лувсанбалдан	Дугаар	L159
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Галуут
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баянхонгорын хүрээ	Сүм хийдийн дугаар	БХГТ 091
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 7	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Галуут сумын Баянхонгорын хүрээ

Асуулт:-Баянхонгорын хүрээний талаар та юу мэдэх вэ?

Хариулт:-Баянхонгорын хүрээний талаар нэг их онц тодорхой мэдээд байхаар зүйл байхгүй. Гэхдээ хөгшчүүлийн ярьж байсан юм бий. **Дашдоо** гүний хүрээ гэж байсан. Анх эхлээд үүсгэн байгуулахдаа эсгий гэртэй байсан гэж байгаа. Тэгээд эсгий гэрийнх нь зайгаар шар шувуу **төрчихөөд** байдаг байсан. Тэгээд Шар шувуутын хийд гэж нэр авч байсан ийм юм билээ. Тэр үед **Нүгнээч** гэж нэг хүн байсан гэж байгаа юм. Тэр хийдийн л гол хариуцах эзэн нь байсан бололтой юм билээ. Тэр **Нүгнээч** гуай гол нь үүсгэн байгуулсан гэж ярьдаг юм байгаа юм. **Яахав** дээ сүүлийн **үед өргөжөөд** дуган сүмтэй ч болсон, **бурхан шашных** нь ч. **Дашдоо** гүний хүрээний гуулин бурхан, сэрсэн бурхан ч гэж ярьдаг юм. Тэр бол хошуунд байхгүй сайхан, олон сайхан суумал ийм сэрсэн бурхантай, 7 дугантай.

Асуулт:-Юу юуны дугантай байсан юм?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Майдарын дуган, **Цогчэн** дуган, **чойр** дуган, гол дуган, **манбын** дуган гээд 7, 8 ийм дуганууд байсан. Майдарын дуган гэж нэг дуган байсан. Майдарын дуганд дандаа ном судар хадгалдаг гэж ярьж байсан юм. Би бол энэ хамгийн сүүлийн **Майдарыг** үзсэн хүн. Хэдэн оныг бүү мэд.

Асуулт:-Хэдэн настай байсан та?

Хариулт:- Тэгэхээр жаахан байсан байгаа юм. 5, 6 насны л, гэхдээ л мэдээд байдаг юм. 70 хэдэн цамтай байсан юм. Хошуунд байхгүй суварга гэж байсан, 7 суваргатай байсан. 7 суваргатай, 7 дугантай. Хамгийн сүүлд Дүйнхэр дуган гэж дуган баригдсан. Тэгээд **сэмчингүүд** гэж байсан. Одоогоор бол соёлын **төвүүдэрхүү**. Дээр үед улаан булан гэж ярьж байсан. Тийм гоё гоё гэгээний сэмчин байсан, бас нэг сэмчин байсан. Тэрэнд чинь ерөөсөө л зураг хөрөг, **бурханы** зураг хөрөг, тамд орсон, тамаас гарсан, нүгэл буян өгүүлсэн тийм болно гээд дандаа тийм юм өгүүлсэн тийм байсан. Гэгээний сэмчин гэдэг бол ийм юм билээ. Гэгээн багшийг чинь баруун зуугаас залж ирдэг байсан. Баруун зуугаас залж ирэхэд нь 1 хар хүн, 1 лам хүн явдаг.

Баянхонгор аймгийн Галуут сумын өндөр настан Лувсанбалдан гуайн Баянхонгорын хүрээний тухай ярианы үргэлжлэл

Асуулт:-Хаанаас ямар хүн залдаг гэлээ?

Хариулт:-Баруун Зуугаас Төвд лам, гэгээн багш гэдэг хүн залж ирдэг байсан гэж байгаа юм. Тэр гэгээн багшийг залж ирэхэд 1 хар хүн, 1 лам хүн явдаг. Лам хүнд нь Очир **аранжанба** гэдэг хүн явдаг байсан гэж байгаа юм. Хар хүнд нь хангайгаас хэн билээ нэг хүн явдаг гэсэн.

Асуулт:-Байнга явдаг юмүү? Жил бүр?

Хариулт:-Үгүй ээ. 3 жил болоод нэг залж ирдэг гэж байгаа юм. Тэгээд энэ Гэгээн овоо гэж энэ овоог тахина. Энэ овоог тахина, наадам хийнэ, морь уралдана, тэгээд энэ хошууны ард түмэн ерөөсөө мөргөл хийгээд, мөргөж сөхрөөд ингээд л тэгээд буцдаг. Нэг тийм гэгээн залж ирдэг байсан гэж байгаа юм. Энэ **Дашдоо** гүний хүрээ.

Дашдоо гүний хүрээний хувьд бол жил болгон **Майдар** эргэнэ. Жил болгон сор зална. 75 цам тоглодог. Одоогоор дандаа л жүжиг л байгаа юм. Би тэр хамгийн сүүлийн Майдарыг үзсэн хүн. Хамгийн сүүлийн дом хийдэг хүнийг үзсэн хүн.

Асуулт:-Дом хийдэг хэн гэж хүн байсан юм бэ?

Хариулт:-Барамсай гэдэг хүн дом хийсэн юм байгаа юм. Тэгээд тэр Майдарын тухайд бол ерөөсөө их л гоё юм болдог байсан юм. Хамгийн эхлээд урд үүд гэж гарна. Анх урагшаа гарна. Майдарын жааз гэдэг юм одоогоор бол 10-аад метр өндөр тийм жааз байсан юм. Тэр жаазандаа торгон **Майдар** гэж юм үлээлгэнэ. 80 тохой гэж ярьж байсан юм. Тэгээд тэр үед чинь амьтан мөргөж, **сөхрөнө**. Тэгээд баруун үүд гэж баруун тийшээ дугуйрдаг. Баруун үүд дээрээс чинь эхлээд алтан **Майдар** гэж нэг улаан морин тэрэгтэй, тэгэхдээ ногоон морины цээжтэй, **тэрэн** дээр нэг лам суучихсан явна. Тэгээд өдий зэргийн гуулин **бурханаар** адис тавьдаг л байсан, алтан **Майдар** гэж. Тэгээд ерөөсөө баруун үд, хойд үд, зүүн үд. Зүүн үд дээрээс дотогшоо ордог байсан. Гэхдээ дандаа дэг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

жаягтай, баруун үд дээр тийм юм тоглоно, хойд үд дээр тийм. Лав л хойд үд дээр хоёр буга тоглодог байсан юм даг. Тэгээд зүүн үд дээр юу хийдэг юм, бага байхад сайн мэдэхгүй. Тэгээд **Майдар** дотогшоо орно. Майдар **бурханыг Майдарын** дуганд нь залдаг тийм л байсан юм.

Сор зална гэдэг чинь бас л урд үд дээрээс сороо залдаг.

Асуулт:-Майдарын урд уу?

Хариулт:-Тийм. Сор залах чинь урд хөгшчүүл ярьдаг байсан юм. Тэр бүхэл бүтэн жилийнхээ муу муухай юмыг л устгадаг, үгүй хийдэг, тийм номтой, тийм дүрэмтэй тийм л байсан гэсэн. Хамгийн сүүлийн **Майдарын** жил сорынх нь гал амьтны толгой дээгүүр сөрөөд **явчихаж** байсан юм. Буцаад. Ийшээ явах байсан бол тийшээ яваад. За одоо ч цаг төр ч өөдтэй болохгүй байх, сорын гал сөрчихлөө, олигтой юм болохгүй гэж байсан юм. Тэгээд л тэрнээс хойш Майдар эргээгүй, дуган сүм баларсан. Тэгэхэд чинь ярихгүй том хөө, хуяг зөөсөн баатрын дуулгатай хүн буу барьж буудна, хажууд нь сор балин гэдэг чинь томоо тавган дээр том лүд юм хийчихсэн, тэрнийгээ цаад талд нь тавьж шатаана. Тэр том бараг метр өндөр шахуу том гурвалжин улаан балин. Тэр улсууд ярьж байхад, тэр сор залж яваа хүн, залах гэж барьж яваа хүн газар гишгэж байгаа, үгүй хоёроо мэддэггүй байсан гэж. Гал ч **оволзоод** буу ч дуугарна, толгойгоор нь шаагаад хийчихдэг байсан юм гэсэн тэр сороо. Тэр балингаа. Тэгж л залдаг байсан юм даа.

Тэр жилийн сорыг тийм боллоо гэсэн тэрнээс хойш **Майдар** ч эргээгүй, сор ч залаагүй тэгээд дууссан юм.

Асуулт:-Хичнээн тооны ламтай байсан?

Хариулт:-70 хэдэн **дооромбо** баригдсан гэж. Багцаалбал 200, 300 шахам ламтай байсан юм болов уу. Ер нь их байсан юм шүү. Дээр үед чинь ийм дэг жаягтай байлаа. Хоёр хүүтэй хүн бол 1-ийг нь заавал шашны сүм хийдэд суулгана, 3 хүүтэй хүн бол 2-ыг нь ч юмуу, нэгийг нь малчин ч болгодог, ард иргэд ч болгодог тийм л байсан юм. Олон ламтай байсан.

Асуулт:-Энэ хүрээнд байсан томоохон лам нараас хутагт хувилгаадынх нь нэрийг ч юмуу, эсвэл тэрүүн лам нарын нэр усыг мэдэх үү?

Хариулт:-Олонд алдаршсан **Эрдэнэчоймбол** гэдэг том ламтай, эрдэмтэй байсан гэж байгаа юм. Энэ хүрээнд. **Эрдэнэчоймбол** гэж энд тэндгүй яригдаад, бичигдээд байгаа юм. Баруун зууд очиж шавилсан хүн гэж байгаа юм. **Эрдэнэчоймбол** гэдэг хүн. Тэгээд эрдэмтэй, номтой гэж гайхуулаад баруун зуу гэж дээр үеийн улсууд ярьдаг байсан. Хэсэг зэрлэг улсууд байдаг. Тэр зэрлэгүүдтэй нийлээд алга болсон тэр эрдэмтэй хүн. Зэрлэгүүд нь яадаг байсан юм гэнэ лээ, ууланд **гарчихаад** дэмий тэнэж явдаг юмуу, голын усанд толгойгоо дүрээд, толгойгоо дүрсэн усаа элстэй норгоод ингээд толгойгоо бүр элсэн бага хийчихсэн. Тэгээд зодоон хийж явдаг. Тэгээд баруун зууд хаанахын ч юм лам ирсэн гэж байгаа юм, их мундаг ном хаядаг. Баруун **зуугийнхан** ерөөсөө хүч хүрээгүй гэж байгаа юм тэрнийг.

Асуулт:-Эндээс явсан ламыг үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тийм, эндээс явсан **довдого** нартай нийлээд алга болсон ламыг. Тэгээд баруун **зуугийнхан** энийг ч барахгүй юм, **довдого** цоохор нэртэй болсон гэж байгаа юм, тэр. **Довдого цоохорыг** л авчирвал магадгүй, тэр л нэг дийлж магадгүй гээд тэрнийгээ нэг юм **сурч** байгаад **довдого цоохорыг** авчирч багш нь ч байж, ингээд ийм ийм болсон, чи л нэг дийлбэл дийлнэ, дийлэхгүй бол дийлдэхгүй болж байна ингэсэн. Тэгсэн чинь за тэгээд дийлэх юм бол ном, хувцсыг нь сольдог юм байж, лам хувцсаа өмсөөд ном хаялцах болсон. Тэгээд ном хаялцаад эхлэхээр нь багш нь яадаг бол бардаггүй байхдаа гэж бодоод эрхээ бариад дуганаа тойроод явж байсан чинь тэр сүрхий гаднаас ирсэн лам нь 3 онгод өгөөд, 3 дасгал авсан хүнийг би шаахайнаас нь адис авна гэсэн гэж байгаа юм. Энэ юу болдог юм бол. Тэгсэн чинь яг тэр дуганыхаа баруун талд нь очиход 1 онгод өгөөд 1 дасгал авсан гэж байгаа юм. Тэгээд явж байсан чинь яг хойд талд нь очиход бас 1 онгод өгөөд, 1 дасгал авсан гэж байгаа юм. Тэгээд нэг л юм нэхэлцээд байгаа юм шиг. Тэгээд зүүн талд нь ирэхэд бас дахиад дохисон гэж байгаа юм. За энэ ч болохоо байлаа гээд шалавхан гүйгээд ороод ирсэн чинь **шахайгаа тайлчихаад** зогсож байсан гэж байгаа юм, шаахайгаар адис өгөх гээд. **Яахав** нэг ном алдсан юм чинь. Тэгээд болдоггүй юм, тэгдэггүй юм, болохгүй гээд шаахайнаас нь адис авахуулаагүй юм гэнэ лээ.

Тэгээд за да чи ч энэ нутагт байж болохгүй байхаа, маргааш юмуу, чамайг би явуулна, нутагт чинь гээд.

Асуулт:-Нааш нь явуулах гэж байгаа юмуу?

Хариулт:-Тийм, нутаг руу нь явуулахгүй юу.

Асуулт:-Тэгэхгүй бол зэрлэгүүдтэй нийлж яваад байсан?

Хариулт:-Тийм. Зэрлэгүүдээс нь салгаж аваад тэгээд хоносон гэж байгаа юм. Унтдаг орон доор нь шуудайтай билүү элс тавиад өөрийг нь наагуур нь унтуулаад тэгээд хоносон гэж байгаа. Тэгээд маргааш өглөө нь цаанаас нь хутгаар нь дүрээд байсан гэж байгаа, шуудайтай элсийг нь. Ингэнэ. Чи бол энд байж болохгүй.

Асуулт:-Хэн дүрсэн байж таарах вэ?

Хариулт:-**Яагаав**, дээр үед чинь хор атаа жөтөө, энэ эрдэмтэй сүрхий хүн юм гэдгийг алах гэж байхгүй юу. Тийм хорлонтой байхгүй юу. Тэгээд явуулсан гэж байгаа юм даа, нааш нь. Тэгсэн чинь бас болоогүй. Багш нь нэг жаахан ууттай замбаа, бор гурил өгсөн гэж байгаа. **Тэрэн** дотор нь 50 лангийн ембүү хийж өгсөн гэж байгаа. Өнөөх нь явсан чинь хойноос нь бас өнөө **дайсангууд** нь ирээд зодож, нүдээд, арай л алаагүй гэж байгаа юм. Тэгээд нөгөө жаахан бор гурилыг нь **асгачихаад** уутыг нь сэгсэрч хаяад явсан гэж байгаа юм. Тэгээд **яахав** нэг юм амь гараад тэгээд нөгөө гурил дотроосоо ембүүгээ аваад тэгээд аянчин дагаад тэгээд ирсэн гэж байгаа. Тэрний бүтээсэн ном судар, сан байдаг юм шүү дээ, Баянхонгорын санг бүтээсэн л хүн гэж байгаа юм.

Асуулт:-Зохиосон хүн юм уу?

Хариулт:-Тийм. Зохиосон. Том эрдэмтэн хүн гэж байгаа. Тэгээд энэ түүх шастирын **номнууд** зарим газар байж л байдаг гэж байгаа. Тэрнийг дээд талд мэднэ. Нэг тийм том лам байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Өөр ямар хувилгаан хүмүүс байсан?

Хариулт:-Өөр хувилгаан гэх юм байхгүй. Сайн сайн эрдэмтэй лам нар байсан юм гэдэг шүү. Бөндгөр Самдан гэж нэг сүрхий хүн байсан юм гэнэ лээ. Тэр улсууд л ярьж байсан, тэр үхсэн хүнийг сэхээдэг байсан гэж байгаа шүү.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нэг ийшээ хаана **ч гэнэв** бадар бариад тэгээд дэмий тэнэж явсан. Тэгсэн чинь цуг бас нэг хүнтэй явжээ. Тэгээд чи бушуу яваад байгаарай, хурдан явахгүй бол **болохгүй**. Тэгсэн айлын нүүгээд явчихсан хар бүүр байна гэнэ. Хар бууран дээр нь үхсэн хүн байна гэнээ. Бушуухан буугаарай, бушуухан гал **түлээдэх** гэсэн гэж байгаа юм. Энэ үхсэн хүний дэргэд галладаг яах гэж байгаа юм бол гэсэн чинь. Мөнгөн тэвнэ гэл үү, алтан тэвнэ гэл үү улайсгасан гэж байгаа. Тэгээд улайсгаж байгаад тэр үхсэн хүнийг очоод юу руу нь билээ хатгачихсан гэж байгаа. Сүвээ рүү нь **гэлүү** хаана нь гэлээ хатгасан гэж байгаа. Тэгсэн чинь өнөөдөх нь ёх гээд амьсгаа аваад амьсгалж байсан гэж байгаа. Тэгээд тэр жирэмсэн хүн байсан гэж байгаа. Тэгээд нөгөө лам дээлээ өмсгөж гэнэ. Танайхан хаа байсан гэсэн чинь манайхан энд л байсан ингээд алга **болчихоод** байна, тийшээ л нүүсэн байдаг юм болов уу даа гээд нэг чигийг зааж өгсөн.

Тэгээд бас л тэр өөд явж өгч гэнэ дээ. Хүрээд очсон чинь баян тарган ч улсууд юм гэнэ. Ийм ийм юм боллоо гээд, хоёр лам хойдох урдах юмыг нь уншаад байж гэнэ. Танай энд чинь хүнээ амьдаар нь хаячихдаг юмуу хаашаа байна гэсэн өнөөдүүл чинь гайхсан гэж байгаа. Танай хүн чинь амьд л юм байна шүү дээ. Тэр хүнээ явж ав ав манайхаас. Жодгор шаачихсан тэнд. Бүр мэл гайхаж хоцорсон гэнэ. Гайхаад байх юм байхгүй хувцсыг нь аваад яв очоод ав гэсэн гэж байгаа. Тэгээд очоод авсан гэж байгаа. Тэгж сэхээсэн гэж ярьдаг юм хуучцуул. Тэр бол тун сүрхий хүн байсан гэж байгаа юм. Дээр үеийн янз бүрийн юмнууд ярьдаг юм.

Асуулт:-Өөр эрдэмтэй ямархуу лам нар байсан? Та унзад нь тийм хүн байсан, хамба нь тийм хүн байсан гэсэн нэр ус мэдэх үү?

Хариулт:-Баруун цорж, зүүн цорж гээд тал талаар нь цохидог байсан юм гэнэ лээ. Тэгээд баруун цорж лам, зүүн цорж лам гээд байдаг байсан, би ямар **юм мэдэхэв**, ер нь тийм л зохион байгуулалттай, тэгээд **гэсгүйтэй**, няравтай, **гониртой**.

Асуулт:-Хамгийн сүүлд баригдаж яваад хэлмэгдсэн хүмүүсийн нэр усыг мэдэх үү?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Баригдаж яваад ихэнх нь алагдсан уу?

Хариулт:-Тэгэхгүй **яахав**. Цөөхөн хүн гарсан. Хамгийн анх эхлээд 3 хүн баригдсан, Ишжамц, Мягмар, Дагва зурхайч гэдэг хүн нэг хэсэг баригдаж явсан байх.Тэр гурав харин буцаж ирсэн. Дагва зурхайч ч зурхайч хүн байсан. Ишжамц нь зүгээр нэг унзад хийдэг хүн байсан. Мягмар гэлэн гэдэг нь зүгээр мяндагтан. Ямар журмаар баригдсан мэдэхгүй, тэр гурав л буцаж ирсэн. Бусад нь явсан.

Асуулт:-Хэдэн оны үед?

Хариулт:-38, 39 оны үе юм болов уу даа. Лам нар чинь хурал **хаагдчихаад**, хөдөө **гарчихаад** хөдөөгүүр явчихсан байсан шүү дээ. Тэгээд л бариад байсан. Лам нар баригдаж гэнээ л гэж дуулдаж байсан юм, би жаахан хүүхэд. Тэгээд манайд нэг Бямбадорж гэдэг сайхан том цагаан лам дөхөж өгөөд тэгээд л явсан. Тэнтгэр Жаргал гэдэг хүний дүү гэж гэж байсан. Тэгсэн Бямбадорж баригдаж гэнээ гээд манай аав, ээж тэгж ярьдаг байсан. Тэгээд ерөөсөө Архангайд ачаад явсан гэж ярьдаг юм шүү.

Асуулт:-Тэд нарыг үү? Бөөнд нь авч яваад.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тийм .Тэр үед манайх Архангай аймагт захирагдаж байлаа. Тэгээд Архангайд очоод. Дарагдаж үхсэн гэж ярьдаг юм.

Асуулт:-Үхсэн хүмүүст дарагдаж үхсэн гэсэн үг үү?

Хариулт:-Багтахгүй орон гэрт аваачаад ингээд ингээд чихээд **хаячихаж** байгаа юм чинь. Зарим үед хэтэрсэн юм шүү. Аюултай.

Асуулт:-Та хүрээний жас, хөрөнгө малынх нь тухай ярихгүй юу?

Хариулт:-**Нүгнээ** жас, **Цогчэн** жас, Чойр жас, **Гадаасан** гэж ийм 4, 5 том жастай. Тэрүүнд чинь байхгүй юм гэж байхгүй. Мал, адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа бүгд.

Асуулт:-Багцаа тоо нь хичнээн юм болох вэ?

Хариулт:-Тэрэнд чинь төвд нь тэмээний хомбон, ширдэг, тос, гурил, будаа, замбараа байхгүй. Ерөөсөө их юм байсан байгаа юм.

Асуулт:-Томоохон ном, судрууд, эрдэнийн судар, **Ганжуур, Данжуур** ч гэдэг юмуу?

Хариулт:-Байна. Байлгүй **яахав**. Майдарын дуган гэдэг чинь ингээд одоогоор хааш хаашаа дуган чинь 10-аад метр шахуу тэг дөрвөлжин юм байсан юм. Тэр үед чинь Майдар ын дуган гэдэг чинь нүдтэй шкафнууд хийчихсэн. Судруудыг чинь чигжчихсэн. Ганжуур, **Данжуур** хөлгөн судруудыг чинь овоолттой байсан байхгүй юу. Цөмийг нь шатаачихсан юм.

Асуулт:-Сүм хийд нураагдах үед бүгдийг нь шатаасан юмуу?

Хариулт:-Бүгд шатаасан.

Асуулт:-Бурхан тахилыг нь яасан юм бэ?

Хариулт:-Бурхан тахилыг нь. Тэд их хорлонтой. Том суумал бурхан бий шүү дээ, сэрсэн бурхан ч гэдэг, гуулин бурхан ч гэдэг. Эд нарыг чинь унагаад хөлийг нь нэг **тасдаад**, гарыг нь нэг тасдаад, толгойг нь тасдаж хэмх хэмх цохиод хаячихна. Тэгээд Архангай руу ачсан юм. Архангай аймагт захирагдаж байсан юм. Аймагт хүргэх гээд. Энэ дээр Хуримт нуур гэж нэг нуур байсан юм. Тэр лүү үхэр явахгүй байна, хонь явахгүй байна гээд байсан. Сүүлд нэг жаахан сэг ухаж гаргасан, тэгээд байхгүй. Дэндүү их хөрөнгө байсан, их ч юм байсан, байхгүй.

Асуулт:-Дуганы барилга нь юугаар хийгдсэн байсан?

Хариулт:-Дандаа тоосго

Асуулт:-Модон дээвэртэй тоосго

Хариулт:-Тийм модон дээвэртэй тоосго.

Асуулт:-Сүүлд яаж тэрнийг устгасан, юу хийсэн, нураагдаж барихаар нь?

Хариулт:-Ийш тийш нь зөөгөөд, байшин барилга бариад, юм чинь яваандаа явсаар байгаад устчихдаг юм байна шүү дээ. Энд нэг л байшин барилга байжээ дээ гэмээр суурь нь байгаа биз дээ. Харин төвд нь сууж байсан лам нар нь жорлон гээч юм байхгүй. Ерөөсөө жорлон байхгүй, жижигхэн хашаатай ил задгай бие засдаг, тэр нь хогийн нохой гэж нохой зөндөө, тэрнийг нь түүгээд идчихдэг. Жорлон бол дээр үед байгаагүй. Дээр үеийн

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

дугануудыг чинь галладаггүй байсан юм. Гал түлэхгүй. Том том сэгсэн дээлтэй, том том дээлтэй лам нар хуралдаа ирээд суудаг.

Асуулт:-**Дашдоо** гүний хүрээний лам нар Төвдийн ч юмуу, бусад гадаадтай ямар харилцаа холбоотой байсан бол?

Хариулт:-Ер нь юмтай холбоотой байсан гэж ярьдаг юм шүү. Манай хүрээг тун сүрхий хэлмэгдсэн. Гэндэн билүү, Дэמיד нь билүү нэг хүн ирээд хазгар Гэндэн гэдэг хүн ирээд хүрээний дааж байсан 4 лам байсан, нэг нэг хамрын тамхи **өгчихөөд** явсан юм гэнэ лээ. Тэгсэн чинь тэр үед харьцаа нь нууц **бичгэнд** байсан юм гэнэ лээ гэж ярьдаг байсан, хөгшчүүл. Ер нь юм ч өнгөрч, тэрний юм өнгөрөөд дахиад нэг засаг төр үүсчихсэн, айл амьтан хүн ярьж байхад Өвөрхангай эд нараас цаашаа Хятад руу явж хэлэлцээр хийгээд ирдэг тийм лам, тийм улсууд байсан гэж ярьдаг юм шүү. Манай хүрээг яриа байхгүй, тэр эсэргүү ч юу **байхав** дээ, зарим нь Японыг дагана, зарим нь Оросыг дагана гээд хоорондоо зөрөлдөж байлаа шүү дээ. Тэгэхээр зэрэг чухам аль нь зөв байсан юм, бүү мэд. Буруудсан л юм байхгүй, монголын тусгаар тогтнол, Монгол Улс ямар ч гэсэн хамгаалагдаж хоцорсон л юм.

Асуулт:-Төвдийн лам нартай холбоотой байсан уу?

Хариулт:-Холбоотой байхаар барахгүй, Төвдийн гэгээнийг залж ирж шүтдэг, Төвдөд эндхийн том хүн нь очиж сургууль, соёлд нь сурч, том эрдэмтэн болсныг бодохгүй юу. Тэр чинь холбоотой байхгүй **яхав**, бүр шууд сайн холбоотой.

Асуулт:-Түрүүний хэлдэг сүрхий эрдэмтэн хүн чинь Төвдөд очсон уу?

Хариулт:-Тийм. Тэр чинь холбоотой байж байж тэнд сурч ирсэн хүн. Тэгээд Төвдөд их явж байсан байгаа юм улсууд.

Асуулт:-Сүүлд лам нар тарсны дараа хийдийн барилга, тоосгыг нь нурааснаас хойш байхгүй болсон.

Хариулт:-Байхгүй. **Асарын** том том төмөр баганууд сайхан, иш нь нохой шээгээд гадуур хэвтдэг юм шүү дээ, нэг хэсэг барагдахгүй л их юм байсан, тэгээд дороо л арилчихсан.

Асуулт:-Энүүгээр хятад худалдаачин, наймаачид хүрээ дагасан хүмүүс байсан уу?

Хариулт:-Байлгүй **яхав**. Зөндөө. Одоо энэ манай аймгийн төвөөр чинь хятадын суурингууд энэ доошоо бөмбөгөр лүү хадны өвөрт нэг том хятадын суурин байсан. Одоо энэ аймгийн төвийн доод руу нэг том суурин байдаг юм, энэ Мандалын **хангайгаад** нэг суурин байдаг юм, хятадууд яваад суурьшаад нэг хэсэг байж байгаад нүүгээд ингээд байсан. Хамгийн сүүлд манай энд Далай наймаа, Буяндалайн **наймаанууд** гээд байж байсан. **Дайпийнх**, Түншийнх гээд зөндөө юмнууд байсан. Манжийн дарлалд 200 гаруй жил дарлагдсан Манжийн **хааныхан** гэдэг чинь манж чинь монголыг баллах гээд байсан өөрөө сүүлд нь **баллуулчихаа** биз дээ, манж гэж юм байхгүй биз дээ.

Асуулт:-Ном судраа хэвлэдэг модон бар ч юмуу, тийм хэвлэх үйлдвэр маягийн юм байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Байлгүй яадаг юм. Бартай байсан газар. Тэрнийг чинь хийдэг улсууд ч байдаг юм шүү дээ. **Манайхны Дасгаа гэж** хүн байсан. Их уран. Нэг их том судар ч үгүй, энэ хярааны модон дээр сийлээд, зөөлөн модон дээр харулдаад аль дуган сүм өнгөрсөн хойно. Тэгээд бэх түрхээд, тэгээд дээрээс нь цаас тавиад ингэчихнэ.

Асуулт:-40 см хэрээтэй юм байна тийм ээ?

Хариулт:-Тийм. Тийм модон бар. Дээр үед чинь модон барын хэвлэл, төмөр барын хэвлэл гээд хоёр барын хэвлэл байсан юм гэнэ лээ. Манай энд байгаагүй юм байхгүй, цөм байсан юм. Тэгээд цөмийг нь ингээд дуусгаад хаячихсан. Өнгөрсөн хойно юмаа барилаа гэдэг шиг. Одоо байсан бол ямар сайхан **юм байхав**.